



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2018 оны 08 сарын 30 одор

Дугаар А/507 .

Булган

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Ойн нөхөрлөлүүдийн ойн санд ой зохион байгуулалт хийх зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 01 дугаартай зөвлөмжийн дагуу “Мөнх ногоон жодоо” ХХК-тай 53 244 070 /тавин гурван сая хоёр зуун дөчин дөрвөн мянга дал/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай

2. “Мөнх ногоон жодоо” ХХК-ийн ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Мөнх ногоон жодоо” ХХК /Л.Ууганбаяр/-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

